



УЛААНБААТАР ХОТЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН  
ТУШААЛ

2019 оны 03 сарын 06 өдөр

Дугаар А/56

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 33 дугаар зүйлийн 33.1, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 3 дугаар хэсгийн 3.1.3, 3.1.21 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Улаанбаатар хотын ногоон байгууламжийн нягтралыг сайжруулах ажлын хүрээнд нийтийн эзэмшлийн гудамж, цэцэрлэгт болон орон сууцны хорооллын дотор байгуулах “Ойн төгөл” -үүдэд 4-6 метрийн өндөртэй том оврын нарс модыг тарих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг 1 дүгээр, хотын зарим гудамж, цэцэрлэгт тарих том оврын нарс модны байршил, тоо хэмжээ, зарцуулах хөрөнгийг 2 дугаар, орон сууцны хороолол дотор байгуулах “Ойн төгөл”-үүдэд тарих том оврын нарс модны тоо хэмжээ, зарцуулах хөрөнгийг 3 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Том оврын нарс мод тарих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг холбогдох хуулийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо /Г.Ууганбаяр/-нд даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР  
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА  Т.ГАНТӨМӨР




Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн  
2019 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн  
А/36 тушаалын 1 дүгээр хавсралт



ТОМ ОВРЫН НАРС МОД ТАРИХ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ  
СОНГОН ШАЛГАРУУЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ  
ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Үнэлгээний хорооны дарга :	Г.Ууганбаяр	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга
Гишүүд:	М.Гансэлэм	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн Ахлах мэргэжилтэн
	Д.Сүхбат	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн Ногоон байгууламжийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн
	Т.Мөнхнасан	Улаанбаатар хот. Сүхбаатар дүүргийн 3-р хороо. 24-р байр. 39 тоотод оршин суугч иргэн. /зөвшилцсөнөөр/
Нарийн дарга:	бичгийн Л.Баатарцогт	Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн Ногоон байгууламжийн арчилгааны асуудал хариуцсан мэргэжилтэн

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн  
 2019 оны 03 дугаар сарын 26 ны өдрийн  
 А/56 тушаалын 2 дугаар хавсралт



ХОТЫН ЗАРИМ ГУДАМЖ, ЦЭЦЭРЛЭГТ ТАРИХ  
 ТОМ ОВРЫН НАРС МОДНЫ БАЙРШИЛ,  
 ТОО ХЭМЖЭЭ, ЗАРЦУУЛАХ ХӨРӨНГӨ

Багцын дугаар	Мод тарих байршил	Тарих модны тоо /ширхэг/	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Нийт зардал /төгрөг/
1-р багц	Баянзүрх дүүрэг. Энхтайваны өргөн чөлөө /Зүүн 4 замын уулзвараас Эскадрилын хөшөө хүртэл автозамын голын бульварт/	685	380.000	260.300.000
	<b>дүн</b>	<b>685</b>		<b>260.300.000</b>
2-р багц	Баянгол дүүрэг. Энэбишийн өргөн чөлөө /1000 нэрийн барааны дэлгүүрийн зүүн урд уулзвараас Номин супермаркет хүртэл/	400	380.000	152.000.000
	<b>дүн</b>	<b>400</b>		<b>152.000.000</b>
3-р багц	Баянгол дүүрэг. Ард Аюушийн гудамж /Номин супермаркетаас тролейбусны эцэс хүртэл/	400	380.000	152.000.000
	<b>дүн</b>	<b>400</b>		<b>152.000.000</b>
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>1485</b>	380.000	<b>564.300.000</b>

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн  
2019 оны 03 сарын 16 өдрийн  
А/56 тушаалын хавсралт



ОРОН СУУЦНЫ ХОРООЛОЛ ДОТОР БАЙГУУЛАХ  
"ОЙН ТӨГӨЛ"-ҮҮДЭД ТАРИХ ТОМ ОВРЫН НАРС  
МОДНЫ ТОО ХЭМЖЭЭ, ЗАРЦУУЛАХ ХӨРӨНГӨ

Багцын дугаар	Дүүргийн нэр	Тарих модны тоо /ширхэг/	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Нийт зардал /төгрөг/
1-р багц	Сүхбаатар /146ш/, Чингэлтэй /49ш/ дүүргийн орон сууцны хороолол дотор "Ойн төгөл" байгуулах	195	380.000	74.100.000
2-р багц	Баянзүрх /109ш/, Баянгол /80ш/ дүүргийн орон сууцны хороолол дотор "Ойн төгөл" байгуулах	189	380.000	71.820.000
3-р багц	Сонгинохайрхан /50ш/, Хан-уул /50ш/ дүүргийн орон сууцны хороолол дотор "Ойн төгөл" байгуулах, Халдвартын эмнэлгийн орчмыг тохижуулах	198	380.000	75.240.000
	<b>ДҮН</b>	<b>582</b>	<b>380.000</b>	<b>221.160.000</b>